

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/289/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/185

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 80 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019020420

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,065,989.91	117,542,890.69
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	49,517,162.24	80,505,672.47
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	49,517,162.24	80,505,672.47
9	Төгрөг	49,517,162.24	80,505,672.47
10	Төрийн сангийн харилцах	49,517,162.24	80,505,672.47
60	БАРАА МАТЕРИАЛ	36,548,827.67	37,037,218.22
61	Түүхий эд материал	8,450.00	339,550.00
63	Эм боох материал	8,450.00	339,550.00
66	Хангамжийн материал	36,540,377.67	36,697,668.22
67	Бичиг хэргийн материал	2,169,380.00	3,586,380.00
68	Аж ахуйн материал	29,980,896.05	31,701,636.61
72	Хүнсний материал	4,357,101.62	1,376,651.61
73	Бусад хангамжийн материал	33,000.00	33,000.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,118,753,853.73	1,098,101,891.24
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,118,753,853.73	1,098,101,891.24
108	Биет хөрөнгө	1,110,325,853.73	1,089,673,891.24
109	Барилга, байгууламж	1,110,577,975.43	1,110,120,775.43
110	Хуримтлагдсан элэгдэл	(26,313,884.56)	(46,772,605.88)
113	Машин, тоног төхөөрөмж	30,263,654.20	30,224,967.40
114	Хуримтлагдсан элэгдэл	(12,630,833.18)	(13,545,347.51)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,050,425.00	19,634,230.80
116	Хуримтлагдсан элэгдэл	(20,621,483.16)	(9,988,129.00)
126	Биет бус хөрөнгө	8,428,000.00	8,428,000.00
129	Бусад биет бус хөрөнгө	8,428,000.00	8,428,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,204,819,843.64	1,215,644,781.93
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,346,188.00	-
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,346,188.00	-
164	Өглөг	2,346,188.00	-
167	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,346,188.00	-
215	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,202,473,655.64	1,215,644,781.93
216	Засгийн газрын хувь оролцоо	1,202,473,655.64	1,215,644,781.93
217	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	53,150,600.00	53,150,600.00
218	Өмч: -Төрийн өмч	53,150,600.00	53,150,600.00
224	Хуримтлагдсан үр дүн	1,146,051,014.62	1,159,326,135.97
225	Өмнөх үеийн үр дүн	1,146,051,014.62	1,146,155,009.68
226	Тайлант үеийн үр дүн	-	13,171,126.29
228	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,272,041.02	3,168,045.96
232	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,204,819,843.64	1,215,644,781.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1.477.272.743.49	384,275,550.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1.168.526.543.49	55,414,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	1.168.526.543.49	9,449,550.00
20004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		9,449,550.00
20017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	1.131.577.492.44	7,449,550.00
20018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	36.949.051.05	2,000,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		45,964,600.00
23003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох	271.176.100.00	45,964,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308.746.200.00	328,861,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		328,861,400.00
32001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	271.176.100.00	328,861,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	274.799.087.85	371,104,423.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274.799.087.85	371,104,423.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	272.750.718.39	363,096,168.50
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	169.926.845.46	219,393,260.76
10101	Цалин	136.818.788.39	167,976,991.74
10102	Нэмэгдэл цалин	26.400.253.67	43,418,348.70
10104	Урамшуулал	6.707.803	7,997,920.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21.251.022.84	27,166,679.01
10201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14.446.084.33	18,598,929.73
10202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1.726.538.53	2,188,109.47
10203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1.359.630.71	1,750,487.49
10204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	335.281.26	402,834.24
10205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3.383.488.01	4,226,318.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22.862.588.00	35,110,156.79
10301	Гэрэл цахилгааны зардал	3.945.218.00	5,829,989.29
10302	Түлш, халаалтын зардал	18.917.370.00	29,280,167.50
2104	Хангамж, бараа материалын зардал	3.992.233.40	2,554,959.44
10408	Бараа материал актасны зардал	2.910.533.40	2,554,959.44
2105	Нормативт зардал	34.184.681.98	38,810,500.01
10502	Хоол	34.184.681.98	38,810,500.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	239.200.00	424,400.00
10806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	239.200.00	424,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20.294.146.71	39,636,212.49
10901	Бараа үйлчилгээний бусад зардал	6.375.008.00	7,319,500.00
10902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	760.500.00	1,405,200.00
10903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	13.158.638.71	30,911,512.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2.048.369.46	8,008,255.21
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт		8,008,255.21
13503	Төвлөрүүлэх шилжүүлэг		8,008,255.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	1.202.473.655.64	13,171,126.29
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	1.202.473.655.64	13,171,126.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	308,746,200.00	374,926,000.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,466,600.00	46,064,600.00
78	Нийтлэг татварын бус орлого	-	100,000.00
92	Бусад орлого	-	100,000.00
103	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	37,466,600.00	45,964,600.00

106	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	37,466,600.00	45,964,600.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	271,279,600.00	328,861,400.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	103,500.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	271,176,100.00	328,861,400.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	271,176,100.00	328,861,400.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	258,894,037.76	341,127,489.77
148	УРСГАЛ ЗАРДАЛ	258,894,037.76	341,127,489.77
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,845,668.30	333,119,234.56
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	169,977,721.02	219,482,988.48
151	Үндсэн цалин	137,025,678.17	167,678,541.87
152	Нэмэгдэл	26,244,239.45	44,144,659.76
154	Үр дүнгийн урамшуулал	6,707,803.40	7,659,786.85
157	Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	21,200,147.28	27,176,951.29
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,445,612.41	18,656,425.70
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,689,790.36	2,188,109.47
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,351,872.61	1,750,487.49
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	333,291.21	402,834.24
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,379,580.69	4,179,094.39
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	20,516,400.00	37,456,344.79
165	Гэрэл цахилгааны зардал	3,945,218.00	5,176,183.66
166	Түлш, халаалтын зардал	16,571,182.00	32,280,161.13
170	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	-
171	Бичиг хэрэг	103,500.00	-
181	Нормативт зардал	33,822,800.00	35,830,050.00
183	Хоол, хүнс	33,822,800.00	35,830,050.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
189	Урсгал засвар	500,000.00	500,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	813,200.00	771,500.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	813,200.00	771,500.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	9,911,900.00	11,901,400.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	8,411,900.00	9,586,300.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,500,000.00	2,315,100.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,048,369.46	8,008,255.21
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,048,369.46	8,008,255.21
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,048,369.46	8,008,255.21
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	49,852,162.24	33,798,510.23
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	335,000.00	2,810,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	335,000.00	2,810,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	335,000.00	2,810,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	335,000.00	2,810,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(335,000.00)	(2,810,000.00)
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	49,517,162.24	30,988,510.23
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	49,517,162.24
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,517,162.24	80,505,672.47

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,722,600.00	110,241,975.76	226,217,970.00	381,182,545.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,722,600.00	110,241,975.76	226,217,970.00	381,182,545.86
C07	Тайлант үеийн үр дүн	00.00		-1,140,567.96	-1,140,567.96
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,150,600.00	3,272,041.02	1,146,051,014.62	1,202,473,655.64
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,150,600.00	3,272,041.02	1,146,051,014.62	1,202,473,655.64
				103,995.06	103,995.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,150,600.00	3,272,041.02	1,146,155,009.68	1,202,577,650.70
D08	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-103,995.06		-103,995.06
	Тайлант үеийн үр дүн			13,171,126.29	13,171,126.29
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,150,600.00	3,168,045.96	1,159,326,135.97	1,215,644,781.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	49,517,162.24	(49,517,162.24)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ҮНДЭСН ХӨРӨНГӨ	378,378,400.00	297,972,889.77	80,405,510.23	78.7
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	378,378,400.00	297,972,889.77	80,405,510.23	78.7
4	Бараа, үйлчилгээний зардал	378,378,400.00	297,972,889.77	80,405,510.23	78.7
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,171,700.00	219,482,988.48	61,688,711.52	78.1
6	Үндсэн цалин	190,478,300.00	167,678,541.87	22,799,758.13	88.0
7	Нэмэгдэл	81,855,800.00	44,144,659.76	37,711,140.24	53.9
9	Урамшуулал	8,837,600.00	7,659,786.85	1,177,813.15	86.7
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдсөн хэсэг	35,146,700.00	27,176,951.29	7,969,748.71	77.3
12	Тэтгэврийн даатгал	23,899,500.00	18,656,425.70	5,243,074.30	78.1
13	Тэтгэмжийн даатгал	2,811,500.00	2,188,109.47	623,390.53	77.8
14	ҮОМШӨ ний даатгал	2,249,600.00	1,750,487.49	499,112.51	77.8
15	Ажилгүйдлийн даатгал	562,600.00	402,834.24	159,765.76	71.6
16	Эрүүл мэндийн даатгал	5,623,500.00	4,179,094.39	1,444,405.61	74.3
30	Нормативт зардал	46,261,300.00	35,830,050.00	10,431,250.00	77.5
32	Хоол, хүнс	46,261,300.00	35,830,050.00	10,431,250.00	77.5

43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	771,600.00	771,500.00	100.00	100.0
49	Мэдээллийн технологийн зардал	771,600.00	771,500.00	100.00	100.0
53	Бараа үйлчилгээний бусад зардал	15,027,100.00	14,711,400.00	315,700.00	97.9
54	Бараа үйлчилгээний бусад зардал	12,712,000.00	12,396,300.00	315,700.00	97.5
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,315,100.00	2,315,100.00	-	100.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭГ	329,169,400.00	328,861,400.00	308,000.00	99.9
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	329,169,400.00	328,861,400.00	308,000.00	99.9
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүү мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн	329,169,400.00	328,861,400.00	308,000.00	99.9
127	эхний үлдэгдэл	-	49,517,162.24	(49,517,162.24)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	80,505,672.47	(80,505,672.47)	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	14.00	14.00	-	100.0
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	-	100.0
136	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 7 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 87 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 14 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 95 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,824.9 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	49,517.2	80,505.7	30,988.5
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	36,548.8	37,037.2	488.4
Үндсэн хөрөнгө	1,118,753.8	1,098,101.8	20,651.9
Нийт хөрөнгө	1,204,819.8	1,215,644.7	10,824.9
Өр төлбөр	2,346.2		2,346.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	53,150.6	53,150.6	-
Хуримтлагдсан үр дүн	1,146,051.0	1,159,326.1	13,275.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,272.0	3,168.0	103.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,204,819.8	1,215,644.7	10,824.9

2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 30,988.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цалин хөлс, урамшууллаас 61,688.7 мянган төгрөг, нийгмийн даатгал ажил

олгогчийн шимтгэлээс 7,969.7 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 10,431.3 мянган төгрөг байна.

Бараа материал дансны үлдэгдэл 488.4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн бараа, материал худалдан авалт цагаан хэрэглэл 4,620.0 мянган төгрөг, сургалтын хэрэглэгдэхүүн 1,582.4 мянган төгрөгтэй холбоотой байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын ИТХ-ын 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хүүхдийн цэцэрлэгийн 10 нэр төрлийн нийт 9,478.3 мянган төгрөгийн бараа, материал акталсан. Машин тоног төхөөрөмж данснаас 1,966.0 мянган төгрөгийн 3 нэр төрлийн хөрөнгийг, тавилга эд хогшил данснаас 7,512.3 мянган төгрөгийн 10 нэр төрлийн хөрөнгийг тус тус акталсан.

Үндсэн хөрөнгө данс 20,651.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн Өмчийн газрын 2023 оны 6 дугаар сарын 27-ны дугаар 05/170 тоот шийдвэрээр барилга байгууламжийн дансанд дах 2 төрлийн 1,524.8 мянган төгрөг, машин тоног төхөөрөмжийн данснаас 8 нэр төрлийн 2,942.2 мянган төгрөг, эд хогшлын данснаас 9 нэр төрлийн 6,226.3 мянган төгрөгийн хөрөнгийн хасалт хийж, үүнээс дахин үнэлгээний нэмэгдлээр барилга байгууламж данснаас 2 нэр төрлийн 1,067.6 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж данснаас 8 нэр төрлийн 2,059.6 мянган төгрөг, тавилга эд хогшил данснаас 9 нэр төрлийн 4,322.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус 30 хувь бууруулж, данс бүртгэл орлогод авч тайлагнасан байна. Энэ нь хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 329,169.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,964.6 мянган төгрөг зарлагыг нийт 329,169.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 329,169.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 329,169.4 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 329,169.4 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 308,000.0 мянган төгрөг буюу 99,9% хувьтай байгаа нь тодотгосон гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 21,169.4 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалин, нэмэгдлийг 22,799.7 мянган төгрөгөөр, нормативт болон бараа үйлчилгээний зардлыг 10,431.2 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Орон нутгийн төсвөөс 45,964.0 мянган төгрөгийн тогтмол зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1.157.6	962.5	195.1	83.1%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	44,776.3	35,830.1	8,946.2	80.0%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,966.7	2,996.7	0	100%

4	81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,157.6	1,037.0	120.6	89.6%
5	81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	10,664.9	1,843.8	8,821.1	17.3%
6	81834 Боловсролын стандарт	243,604.2	194,032.7	49,571.5	79.7%
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	74,021.1	61,182.1	12,839.0	82.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т: “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	83.1%	1.157.6	962.5
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	80.0%	44,776.3	35,830.1
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	2,966.7	2,996.7
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	89.6%	1,157.6	1,037.0
5	71801-81832	2023-12-31	Нүүдлийн бүлэгт хамруулах	17.3%	10,664.9	1,843.8
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	79.7%	243,604.2	194,032.7
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	82.7%	74,021.1	61,182.1

Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь санхүүжилтийн эх үүсвэр хоцорч орж ирсэнтэй холбоотой байна.

Боловсролын стандарт арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь багшийн орон тоо дутуу байсантай холбоотой цалин, нийгмийн даатгал шимтгэлийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь эрхлэгч, хоёр багш өөрийн зардлаар шинжилгээнд хамрагдсанаас зардал хэмнэгдсэн байна.

Сургалтын үйл ажиллагаа арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь нэмэгдэл цалин, урамшуулал хэмнэгдсэнтэй холбоотой.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь цахимаар тендерт шалгарсан Баясгалант ХХК-с 93,241.1 мянган төгрөгийн хүнс, бичиг хэргийн бараа материал, НИК ХХК-с 300.0 мянган төгрөгийн шатахуун, тослох материал. Өв баян-Улаан ХХК-аас 4,035.0 мянган төгрөгийн халаалт авдаг.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 345,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 6,900.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,520.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 8 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 61,688.7 мянган төгрөгөөр
- Бүх төрлийн даатгалын зардлыг 7,969.7 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 10,431.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Хүүхдийн цэцэрлэг нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 148 мэдээллийг байршуулж 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулан зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын

бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 3 зөвлөмж хэрэгжээгүй тул аудитын тайланд тусган зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт			/мянган төгрөгөөр/ Биелэлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	289.6	1	289.9	100
Албан шаардлага	1	4,357.1	1	4,357.1	100
Зөвлөмж	2	151,908.7	2	151,908.7	100
Нийт дүн	4	156,555.7	4	156,555.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал ажиглагдсангүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,816.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс 1,620.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 3,196.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. 2023 оны 05 дугаар сарын Хүүхдийн хоолны зарцуулалтын тайланг шалгахад хоолны орц нормыг мөрдөөгүй 1,620.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны яамны сайд, Эрүүл мэндийн яамны сайд, Сангийн яамны сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/166,А/222,599 дугаартай хамтарсан тушаалд дурдсан орц нормоор бодоогүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.6-т “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн 1,620.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Бараа, материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн 2023 оны 05 дугаар сарын бараа материалын тайланг шалгахад Бараа, материалын тооллого хийсэн боловч тооцоо бодолтыг зохих хууль журмын дагуу хийгээгүй 2,325.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 -д “анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр

болно” мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “дараах зүйлийг заавал бүртгэнэ” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тооллогыг хугацаанд нь хийж тооцоог зохих журмын дагуу бодож байх

2.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны 05 дугаар сарын Шатахуун зарцуулалтыг шалгахад жолоочийн тооцооны хуудсанд хэрэглэгчийн гарын гарын үсэг байхгүй 870.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр тушаалыг баримтлаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж ,тамга дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүүхдийн хоолны орц нормыг баримтлаагүй	1	1,620.0			1	1,620.0						
2023 оны 05-р сарын Шатахууны тайланд анхан шатны баримтын бүрдэл дутуу.	1	870.7					1	870.7				
Бараа материалын тооллого хийсэн боловч тооцоо боддоогүй	1	2,325.9					1	2,325.9				
НИЙТ	3	4,816.8			1	1,620.0	2	3,196.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансанд байршуулах 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	3,940.1						1	3,940.1
Дүн	1	3,940.1						1	3,940.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn